



## ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Цагдаагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2026/003/НА-СТА-ТШЗ**



Дарга,  
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа  
Утас: 99993365      Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Болдбаатар  
Утас: 99105506      Цахим хаяг: [boldbaatar.kh@audit.gov.mn](mailto:boldbaatar.kh@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Жалбаа  
Утас: 89330330      Цахим хаяг: [jalbaab@audit.gov.mn](mailto:jalbaab@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Улаанбаатар, Засаг захиргаа 10000  
Утас: 7711-14-2000  
Факс: 7711-14-2000

2026.02.13

134-

АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН  
ДАРГА ЦАГДААГИЙН ХУРАНДАА  
Б.ГҮНЧИН-ИЦ-д

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагдаагийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагдаагийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв тогилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журем, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Цагдаагийн газар нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 438.9 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлага, 346.8 сая төгрөгийн өглөг тусгасан байна.

### Аудитын гол асуудал

Цагдаагийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар албан хаагчдын амралтын хөнгөийн хугацааг хянаагүйн улмаас цалин хөлс дасхардуулан олгосон зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

### Бусад асуудлын хэсэг

Цагдаагийн газар нь тайланг онд 5 зорилтын хүрээнд 86 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилт 98.1 хувьтай үнэлэгдсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж тогилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотсод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АУДСУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болсхгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэх болох бөгөөд дангаараа эсвэл нийлж уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>388,102,226.60</b>	<b>855,918,480.47</b>
31	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	68,015,393.70	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	68,015,393.70	0.00
3121	Төгрөг	68,015,393.70	0.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	68,015,393.70	0.00
33	АВЛАГА	0.00	454,422,168.54
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	15,492,278.84
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	438,929,889.70
35	БАРАА МАТЕРИАЛ	320,086,832.90	401,496,311.93
351	Түүхий эд материал	190,667,053.71	220,272,826.71
35110	Тусгай зориулалттай материал	189,832,193.71	219,445,862.71
35130	Эм боох материал	834,860.00	826,964.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,361,450.00	3,307,250.00
354	Хангамжийн материал	126,058,329.19	177,916,235.22
35410	Бичиг хэргийн материал	9,789,426.41	18,238,996.41
35420	Аж ахуйн материал	22,075,245.78	14,494,337.46
35440	Түлш, шатах тослох материал	22,415,000.00	94,760,384.35
35450	Барилгын засварын материал	13,620,627.00	5,428,827.00
35460	Хүнсний материал	903,240.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	57,254,790.00	44,993,690.00
3547003	Бусад хангамжийн материал	57,254,790.00	44,993,690.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,647,028,230.69</b>	<b>6,010,755,230.85</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,647,028,230.69	6,010,755,230.85
392	Биет хөрөнгө	5,318,723,379.09	5,682,450,379.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,387,811,281.00	5,376,018,335.00
39202	Хуримтлагдсан элэгдэл /Барилга, байгууламж, орон сууц	-1,174,027,321.82	1,362,108,824.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,002,809,949.62	1,351,944,113.30
39204	Хуримтлагдсан элэгдэл/Авто-тээврийн хэрэгсэл	-443,294,112.23	-500,181,376.83
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	772,193,249.64	936,719,084.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	-341,678,594.88	-397,175,393.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	91,911,108.62	259,727,692.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	-53,209,373.25	-53,806,603.51
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	57,264,807.00	57,264,807.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	38,576,700.00	38,246,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-19,634,314.61	-24,198,155.09
393	Биет бус хөрөнгө	328,304,851.60	328,304,851.60
39303	Бусад биет бус хөрөнгө	550,000.00	550,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00

39305	Газар эзэмших эрх	328,304,851.60	328,304,851.60
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,035,130,457.29</b>	<b>6,866,673,711.32</b>
<b>4</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>346,817,614.00</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	346,817,614.00
413	Өглөг	0.00	346,817,614.00
4136	Бусад өглөг	0.00	346,817,614.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	346,817,614.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧ</b>	<b>6,035,130,457.29</b>	<b>6,519,856,097.32</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	6,035,130,457.29	6,519,856,097.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,973,078,092.84	1,973,078,092.84
51101	- төрийн	1,973,078,092.84	1,973,078,092.84
512	Хуримтлагдсан үр дүн	2,475,077,181.82	2,959,802,821.85
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	484,725,640.03
51210	Өмнөх үеийн үр дүн	2,475,077,181.82	2,475,077,181.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,586,975,182.63	1,586,975,182.63
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,035,130,457.29</b>	<b>6,866,673,711.32</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>9,203,165,694.02</b>	<b>10,776,518,002.11</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	709,717,154.02	1,098,663,904.11
120	Нийтлэг татварын бус орлого	709,717,154.02	1,098,663,904.11
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	186,679,568.00	144,494,682.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	135,041,323.00	144,494,682.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	51,638,245.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	512,670,950.52	913,906,309.76
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	10,366,635.50	40,262,912.35
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,493,448,540.00	9,677,854,098.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,109,979,200.00	9,428,172,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,109,979,200.00	9,428,172,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	383,469,340.00	249,681,598.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,993,000.00	7,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	111,232,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,244,340.00	242,681,598.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>9,129,037,413.22</b>	<b>10,271,068,380.03</b>

21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,128,413,413.22	10,271,068,380.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,820,910,464.52	8,815,645,715.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,249,736,618.15	7,149,818,543.69
210101	Үндсэн цалин	3,419,596,279.13	4,319,467,592.79
210102	Нэмэгдэл	2,275,036,587.12	2,310,540,284.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	112,518,943.00	298,705,477.00
210104	Урамшуулал	367,609,265.00	205,520,743.00
210105	Гэрээт ажлын хөлс	74,975,543.90	15,584,446.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,667,200.00	166,047,388.75
210201	Тэтгэврийн даатгал	5,791,382.39	18,652,732.22
210202	Тэтгэмжийн даатгал	371,452.28	1,894,345.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	124,074.01	1,514,012.30
210204	Ажилгүйдлийн даатгал	185,726.15	2,152,372.58
210205	Эрүүл мэндийн даатгал	152,194,565.17	141,833,926.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	217,472,577.00	260,112,400.57
210301	Гэрэл, цахилгаан	68,549,600.00	96,540,383.57
210302	Түлш, халаалт	128,044,777.00	142,935,167.00
210303	Цэвэр, бохир ус	20,878,200.00	20,636,850.00
2104	Хангамж, бараа материалын зардал	306,372,953.00	370,819,163.32
210401	Бичиг хэрэг	35,597,290.00	38,259,110.00
210402	Тээвэр, шатахуун	191,423,000.00	253,658,148.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	51,540,512.50	20,068,682.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00	618,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,458,198.50	16,674,700.00
210408	Бараа материал акталсны зардал	13,953,952.00	41,539,823.32
2105	Нормативт зардал	113,440,183.00	30,932,896.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,110,733.00	1,440,296.00
210502	Хоол, хүнс	98,001,450.00	25,486,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,328,000.00	4,006,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	105,582,560.00	76,351,380.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	1,687,500.00
210604	Урсгал засвар	105,582,560.00	74,663,880.00
2107	Томилолт, зочны зардал	29,925,700.00	50,629,000.00
210702	Дотоод албан томилолт	29,925,700.00	50,629,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,066,938.72	66,410,126.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,283,050.00	52,354,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	894,176.72	2,373,388.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	298,500.00	1,177,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,320,000.00	2,717,000.00
210807	Газрын төлбөр	121,392.00	7,631,438.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	149,820.00	157,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	595,645,734.65	644,524,817.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	304,700.00	6,960,800.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,523,916.20	34,759,716.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	581,817,118.45	602,804,301.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,307,502,948.70	1,455,422,664.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,293,502,048.20	1,384,618,302.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	53,697,425.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	588,076,445.00	753,884,913.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	548,138,468.20	529,393,064.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	157,287,135.00	47,642,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,000,900.50	70,804,361.75
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	1,859,577.50	6,579,350.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,141,323.00	64,225,011.75
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	624,000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	624,000.00	0.00
225102	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз гарз/ТӨҮГ/	624,000.00	0.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III = I - II)</b>	<b>74,128,280.80</b>	<b>505,449,622.08</b>
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
5	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>0.00</b>	<b>20,723,982.05</b>
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-бараа материал	0.00	1,219,050.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	19,504,932.05
6	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI = IV - V)</b>	<b>0.00</b>	<b>-20,723,982.05</b>
7	<b>НИЙТ ҮР ДҮН (VII = III + VI)</b>	<b>74,128,280.80</b>	<b>484,725,640.03</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант оны гүйцэтгэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>8,671,186,127.93</b>	<b>9,822,348,780.00</b>
I.1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	8,671,186,127.93	9,822,348,780.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	177,737,587.93	144,494,682.00
120	Нийтлэг татварын бус орлого	177,737,587.93	144,494,682.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	177,737,587.93	144,494,682.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	177,737,587.93	144,494,682.00
120004101	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	135,041,323.00	135,754,682.00
120004104	Журмын хашааны орлого	0.00	8,740,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,696,264.93	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,493,448,540.00	9,677,854,098.00

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,109,979,200.00	9,428,172,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,109,979,200.00	9,428,172,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	383,469,340.00	249,681,598.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,993,000.00	7,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	111,232,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,244,340.00	242,681,598.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>8,575,751,783.00</b>	<b>9,860,234,249.80</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,575,751,783.00	9,860,234,249.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,265,482,282.50	8,312,699,309.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,284,340,700.00	7,208,383,705.78
210101	Үндсэн цалин	3,258,565,753.23	3,803,811,488.30
210102	Нэмэгдэл	2,356,646,519.53	2,775,890,960.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	112,518,943.00	291,164,759.00
210104	Урамшуулал	458,765,504.24	263,149,752.06
210105	Гэрээт ажлын хөлс	97,843,980.00	74,366,746.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,667,200.00	164,974,505.50
210201	Тэтгэврийн даатгал	0.00	12,954,675.50
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	1,506,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	301,130.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	1,205,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	158,667,200.00	149,007,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	206,010,800.00	263,888,602.57
210301	Гэрэл, цахилгаан	68,549,600.00	96,540,383.57
210302	Түлш, халаалт	116,583,000.00	146,711,369.00
210303	Цэвэр, бохир ус	20,878,200.00	20,636,850.00
2104	Хангамж, бараа материалын зардал	294,115,352.50	398,348,830.00
210401	Бичиг хэрэг	35,742,100.00	48,342,350.00
210402	Тээвэр, шатахуун	195,467,240.00	316,685,898.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	52,206,012.50	20,068,682.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00	618,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,300,000.00	12,633,200.00
2105	Нормативт зардал	109,361,900.00	32,517,560.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,470,000.00	2,122,400.00
210502	Хоол, хүнс	96,563,900.00	25,003,160.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,328,000.00	5,392,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	119,693,880.00	89,617,180.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,479,920.00	22,168,700.00
210602	Тавилга	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	166,700.00
210604	Урсгал засвар	109,213,960.00	67,281,780.00

2107	Томилолт, зочны зардал	30,013,800.00	50,629,000.00
210702	Дотоод албан томилолт	30,013,800.00	50,629,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,570,650.00	66,252,826.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,933,050.00	52,354,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	895,300.00	2,373,388.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	300,800.00	1,177,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,320,000.00	2,717,000.00
210807	Газрын төлбөр	121,500.00	7,631,438.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,708,000.00	38,087,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал/Бараа үйлчилгээний бусад зардал	13,708,000.00	2,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,708,000.00	35,587,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,310,269,500.50	1,547,534,939.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,296,268,600.00	1,037,800,688.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	53,697,425.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	588,076,500.00	499,996,799.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	548,139,300.00	436,463,564.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	158,552,800.00	47,642,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,000,900.50	509,734,251.45
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	1,859,577.50	77,096,943.70
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,141,323.00	432,637,307.75
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ( III = I -II)</b>	<b>95,434,344.93</b>	<b>-37,885,469.80</b>
IV	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>79,204,080.00</b>	<b>72,129,923.90</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>79,204,080.00</b>	<b>72,129,923.90</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	79,204,080.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	79,204,080.00	72,129,923.90
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-79,204,080.00</b>	<b>-72,129,923.90</b>
.	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
14	Бусад эх үүсвэр	0.00	0.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙН ХАССАН ЗЭЭЛ	0.00	0.00
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.00	0.00
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	0.00	0.00
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX = VII -VIII)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
XII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>16,230,264.93</b>	<b>-110,015,393.70</b>
XIII	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>51,785,128.77</b>	<b>68,015,393.70</b>

XIV	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	68,015,393.70	0.00
-----	---	---------------	------

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Балансын үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 ОНЫ 01 САРЫН 01-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	2,133,884,592.84	1,586,975,182.63	2,400,948,901.02	6,121,808,676.49
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-160,806,500.00	-160,806,500.00
ДАХИН ИЛЭРХИЙЛСЭН ҮЛДЭГДЭЛ	2,133,884,592.84	1,586,975,182.63	2,240,142,401.02	5,961,002,176.49
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	0.00	98,680,911.56	98,680,911.56
2024 ОНЫ 12-Р САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	1,973,078,092.84	1,586,975,182.63	2,475,077,181.82	6,035,130,457.29
2024 ОНЫ 12-Р САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	1,973,078,092.84	1,586,975,182.63	2,475,077,181.82	6,035,130,457.29
ДАХИН ИЛЭРХИЙЛСЭН ҮЛДЭГДЭЛ	1,973,078,092.84	1,586,975,182.63	2,475,077,181.82	6,035,130,457.29
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	0.00	484,725,640.03	484,725,640.03
2025 ОНЫ 12 САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	1,973,078,092.84	1,586,975,182.63	2,959,802,821.85	6,519,856,097.32

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Өссөн	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I. ОРЛОГЫН ДҮН	9,580,488,300.00	9,572,667,182.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	122,900,000.00	135,754,682.00
Журмын хашааны орлого	0.00	8,740,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9,457,588,300.00	9,428,172,500.00
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	9,579,744,005.50	9,140,029,874.25
Үндсэн цалин	3,412,819,700.00	3,600,607,727.30
Үндсэн цалин	218,484,200.00	203,203,761.00
Нэмэгдэл	2,624,036,800.00	2,635,398,770.18
Нэмэгдэл	142,015,100.00	140,492,190.00
Унаа хоолны хөнгөлөлт	459,979,800.00	291,164,759.00
Урамшуулал	274,621,500.00	263,149,752.06
Гэрээт ажлын хөлс	93,233,800.00	74,366,746.24
Тэтгэврийн даатгал	12,954,675.50	12,954,675.50
Тэтгэмжийн даатгал	1,506,500.00	1,506,500.00
ҮОМШӨ-ний даатгал	301,130.00	301,130.00
Ажилгүйдлийн даатгал	1,205,200.00	1,205,200.00

Эрүүл мэндийн даатгал	141,797,100.00	141,797,100.00
Эрүүл мэндийн даатгал	7,209,900.00	7,209,900.00
Гэрэл, цахилгаан	95,605,600.00	95,605,583.57
Гэрэл, цахилгаан	997,700.00	934,800.00
Түлш, халаалт	144,244,100.00	144,151,769.00
Түлш, халаалт	2,409,900.00	2,559,600.00
Цэвэр, бохир ус	20,290,500.00	20,198,850.00
Цэвэр, бохир ус	524,800.00	438,000.00
Бичиг хэрэг	38,636,900.00	29,051,500.00
Бичиг хэрэг	498,900.00	417,000.00
Тээвэр, шатахуун	288,777,600.00	288,777,600.00
Тээвэр, шатахуун	1,546,900.00	1,546,900.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,146,000.00	10,628,182.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	498,900.00	458,700.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	398,600.00	618,700.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,482,300.00	8,589,700.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	747,400.00	187,400.00
Хоол, хүнс	15,398,600.00	10,009,660.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,987,400.00	3,952,000.00
Багаж, техник, хэрэгсэл	10,755,000.00	10,233,623.90
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,991,600.00	166,700.00
Урсгал засвар	60,115,500.00	59,410,580.00
Урсгал засвар	250,200.00	250,200.00
Дотоод албан томилолт	65,573,500.00	50,475,600.00
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	21,079,400.00	12,282,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	5,591,200.00	2,373,388.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,198,400.00	1,177,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,101,000.00	2,101,000.00
Нийтлэг үйлчилгээний төлбөр хураамж	9,910,900.00	7,631,438.00
Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	3,928,100.00	3,404,700.00
Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	997,700.00	583,200.00
Бусад Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	53,697,500.00	53,697,425.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	774,503,200.00	499,996,799.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	529,393,300.00	436,463,564.50
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,300,000.00	8,298,500.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Гүйцэтгэл
I. ОРЛОГЫН ДҮН	249,681,598.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,000,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	242,681,598.00

II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	243,102,248.00
Бичиг хэрэг	18,873,850.00
Тээвэр, шатахуун	26,361,398.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,981,800.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,043,500.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,935,000.00
Хоол, хүнс	14,993,500.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,440,000.00
Багаж, техник, хэрэгсэл	81,415,000.00
Тавилга	2,650,000.00
Урсгал засвар	7,621,000.00
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	40,072,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	616,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал/Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00
Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	31,599,200.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба юм.

Тус байгууллага нь 2025 онд 5 зорилтын хүрээнд 86 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж, биелэлт 98.1 хувьтай байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Аймгийн Цагдаагийн газар нь үйл ажиллагаандаа Цагдаагийн албаны тухай, Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Цагдаагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

НББ-ын бодлогын баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Цагдаагийн газрын 2025 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 831,543.2 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	68,015.4	0	-68,015.4
Авлага	0	454,422.2	454,422.2
Бараа материал	320,086.8	401,496.3	81,409.5
Үндсэн хөрөнгө	5,647,028.3	6,010,755.2	363,726.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,035,130.5</b>	<b>6,866,673.7</b>	<b>831,543.2</b>
Өр төлбөр	0	346,817.6	346,817.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,035,130.5	6,519,856.1	484,725.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,035,130.5	6,866,673.7	831,543.2

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

- ✓ Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь ахмадын сангийн зарцуулагдаагүй үлдэгдлийг жилийн эцэст төсөвт төвлөрүүлсэнтэй,
- ✓ Авлага, өглөг дансны үлдэгдэл нэмэгдсэн нь жилийн эцэст төрийн сангийн гүйлгээ доголдсонтой холбоотой алба хаагчдад олгох тэтгэмж, урамшууллыг олгож амжилгүй санхүүжилтийг татуулсан, аудитаар илэрсэн зөрчлийг санхүүгийн тайланд залруулж авлагаар тусгасантай,
- ✓ Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь дээд шатны төсөв захирагчаас 34,721.5 мянган төгрөгийн бараа материал нийлүүлсэн, тайлант хугацаанд худалдан авсан материалаас зарцуулалт хийгдээгүйтэй,
- ✓ Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өссөн нь дээд шатны төсөв захирагчаас 782,502.3 сая төгрөгийн хөрөнгө нийлүүлсэн, аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 88,353.3 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, эрх бүхий байгууллагын шийдвэрээр 110,817.8 сая төгрөгийн хөрөнгө акталсан, 205,864.8 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлсэн, тайлан хугацаанд 602,804.3 мянган төгрөгийн элэгдэл тооцсон зэрэгтэй тус тус холбоотой байна.

Санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд төсөвт байгууллагуудаас авсан программ хангамжийн бүртгэл тайлагналтай холбоотой судалгааны талаар: Тус байгууллагын дансанд НББ хөтлөх зориулалттай 550.0 мянган төгрөгийн өртөг бүхий 1 программ бүртгэлтэй байна. Уг программыг 2018 оноос хойш ашиглаж байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төслийг хуулийн хугацаанд боловсруулан дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж, 2025 оны төсвийг 9,580,488.3 мянган төгрөгөөр батлуулжээ. Үүний 9,457,588.3 мянган төгрөг улсын төсвийн санхүүжилт, 122,900.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлого байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх гэсэн 3 хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 9,428,172.5 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоор 144,494.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, жилийн эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 432,637.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Өөрийн орлого батлагдсан төлөвлөгөөнөөс 21,594.7 мянган төгрөгөөр давсан бөгөөд улсын төсвийн санхүүжилт батлагдсан төсвөөс 29,415.8 мянган төгрөгөөр дутуу байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	8,193,514.9	8,129,291.6	64,223.3	99.2
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1,365,894.0	998,456.3	367,437.7	73.1
3	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	21,079.4	12,282.0	8,797.4	58.3
	<b>ДҮН</b>	<b>9,580,488.3</b>	<b>9,140,029.9</b>	<b>440,458.4</b>	<b>95.4</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд төсөвт байгууллагуудаас авах 8 төрлийн судалгааны 3 нь тухайн байгууллагатай хамааралтай байна. Үүнээс программ хангамжтай холбоотой мэдээллийг аудитын тайлангийн 3.4 дэх хэсэгт тусгасан.

- Унаа, хоолны хөнгөлөлт: Тухайн байгууллага нь хоолны мөнгийг олгож байгаа бөгөөд өдрийн ээлжээр ажиллаж буй алба хаагчдад 10.0 мянган төгрөг, шөнийн ээлжээр ажиллаж буй алба хаагчдад 20.0 мянган төгрөгийг сар бүр олгосон нь зах зээлийн үнэлгээтэй харьцуулахад дундаж түвшинд байна гэж үзлээ.
- Орон тооны цомхотгол: Тус байгууллага нь засгийн газраас баримталж буй бодлого чиглэлийн хүрээнд 9 сул орон тоог хасаж төсөвт тодотгол хийсэн байна.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 249,681.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн ГХУСАЗСЗ-ийн санхүүжилт 112,087.4 мянган төгрөг
- Аймгийн Засаг даргын шийдвэрээр олгосон 7,000.0 мянган төгрөг
- Аймгийн ОНХС-аас олгосон 15,500.0 мянган төгрөг
- Орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилт 80,715.0 мянган төгрөг
- Үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлого 34,379.2 мянган төгрөг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тусгайлан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр байхгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аймгийн Цагдаагийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Жалбаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Цагдаагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 41/224 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн тайлангийн нийт зардлаар сонгож 9,129,037.4 мянган төгрөгөөс төгрөгөөс 1.0 хувиар буюу 91,290.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр шинэчлэн тогтоож, нийт зардал 10,271,068.4 мянган төгрөгийн 1 хувь буюу 102,710.7 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн Цагдаагийн газрын шилэн дансны мэдээллийг анхан шатны баримттай тулган шалгахад алдаа зөрчил илрээгүй болно.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа зөрчил илрээгүй

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Аймгийн Цагдаагийн газрын 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх санхүүгийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

1. Тэргүүний алба хаагчдыг шалгаруулж, үр дүнгийн урамшууллаас гадна цалингийн 50 хүртэл хувиар мөнгөн урамшуулал олгосон байна. Ингэхдээ Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны "Цагдаагийн байгууллагын шагналын төрөл батлах тухай" гэсэн А/99 дугаар тушаалд үндэслэсэн байна.
2. Цагдаагийн байгууллагын хүрээнд дотооддоо зохион байгуулсан тэмцээн уралдаанд оролцох баг тамирчдад төсвөөс томилолт олгож, амжилт гаргасан нөхцөлд үр дүнгийн урамшууллаас гадна цалингийн тодорхой хувиар нэмэлт урамшуулал олгож байна. Ингэхдээ ЦЕГ-аас ирсэн тэмцээний удирдамж, ЦЕГ-ын даргын тушаалаар баталсан шагнал урамшил олгох журам, байгууллагын даргын тушаал гаргах журам зэрэгт үндэслэсэн байна.

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцэхгүй байгаа тул цаашид тэмцээн уралдаантай холбоотой зардал төсвөөс гаргахгүй байх, алба хаагчдад үр дүнгийн урамшууллаас бусад хэлбэрээр шагнал урамшуулал олгохгүй байх чиглэлийг орон нутаг дахь нэгжүүдэд өгөх талаар дээд шатны төсөв захирагчид зөвлөмж хүргүүлэх саналтай байна.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 15,492.3 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан байна. Үүнд:

- ✓ Алба хаагчдын амралтын тооцоог хянаагүйн улмаас амралтын мөнгийг цалинтай давхардуулан олгосон зөрчилд төлбөрийн акт тавих шийдэл гаргасанд тухайн байгууллага авлагаар бүртгэн санхүүгийн тайланд залруулах санал ирүүлснийг хүлээн авч аудитын явцад залруулсан байна.

Аудитаар зөрчил илрээгүй байна.

### **5.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй байна.

### **5.2 Албан шаардлага**

Албан шаардлага өгөх зөрчил илрээгүй байна.

### **5.3 Зөвлөмж**

Зөвлөмж өгөх зөрчил илрээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.



